



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 1/167

Мандалговь

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх "Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Г.Самданцоодол	- АЗДТГазар ХШУДАХ-ийн дарга
Гишүүд:	Ц.Бямбацогт	- Иргэний төлөөлөл
	С.Наранчимэг	-ХХҮГазрын халамжийн хэлтсийн дарга
	Р.Булгантамир	-Сайнцагаан сум ЗДТГ-ын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	М.Бат-Эрдэнэ	- ОНӨГ-ын ХАА хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Самданцоодол/-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /М.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200512